	<b>ДҮН</b>	<b>516,879.7</b>	<b>336,774.5</b>	<b>(180,105.2)</b>	<b>53.5</b>

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 179,624.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 14,000.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн орлогоор бүртгэсэн, үйл ажиллагаанд нийт 128,986.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,229,220.0 мянга, эцсийн үлдэгдэл 2,165,777.6 мянган төгрөг болж, 3,063,442.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3,599,886.6	1,279,759.3	(2,320,127.3)
Тээврийн хэрэгсэл	306,741.4	238,961.5	(67,779.9)
Машин тоног төхөөрөмж	750,145.8	392,979.1	(357,166.6)
Тавилга эд хогшил	304,450.1	74,434.7	(230,015.4)
Номын фонд	56,040.3	2,967.1	(53,073.2)
Бусад үндсэн хөрөнгө	126,424.9	146,424.9	20,000.0

Программ хангамж	2,080.0	750.0	(1,330.0)
Бусад биет бус хөрөнгө	83,451.0	29,501.0	(53,950.0)
<b>Дүн</b>	<b>5,229,220.0</b>	<b>2,165,777.6</b>	<b>(3,063,442.4)</b>

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сумын ЗДТГ, ИТХ төсвийн хөрөнгөөр 49,745.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 171,850.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн ба сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан 3,285,038.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	1,893,878.8	2,109,774.8	215,896.0	97.4%
2	ИТХ	50,302.7	56,002.7	5,700.0	2.6%
3	ЕБС	1,284,251.3	-	(1,284,251.3)	0.0%
4	Цэцэрлэг	679,695.7	-	(679,695.7)	0.0%
5	ЭМТ	696,162.0	-	(696,162.0)	0.0%
6	Соёлын төв	624,929.5	-	(624,929.5)	0.0%
	<b>Дүн</b>	<b>5,229,220.0</b>	<b>2,165,777.6</b>	<b>(3,063,442.5)</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 194,540.8 мянга, эцсийн үлдэгдэл 14924.3 мянган төгрөг болж 179,616.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	194,540.8	14,924.3	(179,616.5)	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	24,415.0	485.3	(23,929.8)	3.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	100,145.1	-		
Байгууллагад төлөх өглөг	67,688.1	14,366.9	(53,321.3)	96.3
Хувь хүмүүст төлөх өглөг	2,292.4	72.1	(2,220.3)	-
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>194,540.8</b>	<b>14,924.3</b>	<b>(179,616.5)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцэст санхүүгийн тайланд бүртгэгдсэн 14,924.3 мянган төгрөгийн 14,366.9 мянган төгрөг нь ОНХС-ийн байгууллагад төлөх өглөг, 72.1 мянган төгрөг нь ЗДТГ-ын хувь хүмүүст төлөх өглөг байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,855,250.2 мянга, эцсийн үлдэгдэл 2,282,616.0 мянган төгрөг болж, 2,572,634.2 мянган төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,653,536.9	531,874.8	(1,121,662.1)	23.3
Хуримтлагдсан үр дүн	1,703,101.8	1,176,470.6	(526,631.2)	51.5
Өмнөх үеийн үр дүн	1,703,101.8	3,607,181.2	1,904,079.4	
Тайлант үеийн үр дүн		(2,430,710.6)	(2,430,710.6)	

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,498,611.5	574,270.5	(924,341.0)	25.2
<b>Дүн</b>	<b>4,855,250.2</b>	<b>2,282,616.0</b>	<b>(2,572,634.2)</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,572,634.2 мянган төгрөгөөр буурсан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.4.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.17-ны өдрийн 4/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 278,700.0.0 мянга, татварын бус торгуулийн орлогыг 30,000.0 мянга, нийт 308,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3	4=3-2
<b>Татварын орлого</b>	<b>278,700.0</b>	<b>353,169.0</b>	<b>538,350.9</b>	<b>185,181.9</b>
<b>Орлогын албан татвар</b>	<b>178,000.0</b>	<b>178,000.0</b>	<b>213,921.7</b>	<b>35,921.7</b>
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар	98,000.0	98,000.0	145,823.9	47,823.9
Хувь хүний орлогын албан татвар	20,000.0	20,000.0	19,158.5	(841.5)
Хадгаламжийн хүү	56,000.0	56,000.0	34,415.1	(21,584.9)
ҮХЭХ худалдсан борлуулсны албан татвар	4,000.0	4,000.0	14,524.2	10,524.2
<b>Өмчийн татвар</b>	<b>14,000.0</b>	<b>88,469.0</b>	<b>56,573.3</b>	<b>(31,895.7)</b>
ҮХЭХ-ийн татвар	12,000.0	12,000.0	6,202.6	(5,797.4)
Бууны албан татвар	2,000.0	2,000.0	2,850.0	850.0
Малын тоо толгойн албан татвар		74,469.0	47,520.7	(26,948.3)
<b>Бусад татвар /төлбөр хураамж/</b>	<b>86,700.0</b>	<b>86,700.0</b>	<b>267,856.0</b>	<b>181,156.0</b>
Тэмдэгтийн хураамж	3,000.0	3,000.0	2,866.5	(133.5)
Газрын төлбөр	65,000.0	65,000.0	22,131.7	(42,868.3)
ТТАМ ашигласны төлбөр	700.0	700.0	400.0	(300.0)
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	12,000.0	12,000.0	4,890.0	(7,110.0)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	6,000.0	6,000.0	237,530.3	231,530.3
Бусад татвар			37.5	37.5
<b>Татварын бус орлого</b>	<b>30,000.0</b>	<b>30,000.0</b>	<b>111,062.3</b>	<b>81,062.3</b>
Торгуулийн орлого	30,000.0	30,000.0	111,062.3	81,062.3
Нийт дүн	308,700.0	383,169.0	649,413.2	266,244.2

*Эх сурвалж: Татварын орлогын хэлбэлзэл, татварын байцаагчаас ирүүлсэн судалгаа*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 69.5 хувь буюу 266,244.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн, орлогын нэр төрлөөр авч үзвэл сумын бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагыг суутган төрлөөр бүртгүүлснээр цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар 47,823.9 мянга, 2022 онд иргэд өөрийн үл хөдлөх болон газрыг зарж борлуулснаар үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны албан татвар 10,524.2 мянга, улсын чанарын төв зам дагуу зөрчлүүд болон уул уурхайн зөрчлүүд их гарсны улмаас торгуулийн орлого 81,062.3 мянган төгрөгөөр давсан, 6 ширхэг шонхор шувуу барих гэрээ байгуулан, 235,577.4 мянган төгрөг орсон зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд оруулахаар төлөвлөсөн 8 татварын орлогын төлөвлөгөө тасарсан нь орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ аваагүйтэй холбоотой байна.

Бөмбөгөр сумын татварын байцаагч сумын татварын гүйцэтгэлийн мэдээг 540,491.6 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 2,140.7 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байгаа тул цаашид татварын байцаагч мэдээг үнэн зөв мэдээлэхэд анхаарах шаардлагатай байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор сумын ЗДТГ 1,000.0 мянга, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 41,300.0 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр сумын ЗДТГ орлого оруулаагүй, харин зээл, зээлийн эргэн төлөлт 38,400.0 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,327,936.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,123,675.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 767,884.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 164,898.9 мянган төгрөгийг тогтмол зардалд, 190,892.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.17-ны өдрийн 4/03 дугаар тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 1,327,936.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.17-ны өдрийн 4/03 дугаар тогтоолоор анх 1,327,936.8 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.15-ны өдрийн 7/01 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж, урьд оны үлдэгдлийг 158,235.2 мянга, татварын орлогыг 74,469.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг 13,629.3 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 92,508.4 мянган төгрөгөөр бууруулан анхны төсвөөс нийт дүнгээр 137,866.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,465,803.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Бөмбөгөр сумын 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

Санхүүжих эх үүсвэр	Дүн	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилт	285,505.90	19.5
Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	356,228.40	24.3
Сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого	383,169.00	26.1
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	398,600.00	27.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.00	0.1
Сум хөгжүүлэх сангийн орлого	41,300.00	2.8
<b>ДҮН</b>	<b>1,465,803.30</b>	<b>100.0</b>

Эх сурвалж. Бөмбөгөр сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 08/50 дугаар тогтоол

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр 522,874.9 мянган төгрөгийн 23 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 311,874.9 мянган төгрөгийн 11 төсөл арга хэмжээ хэрэгжээгүйгээс зардлын гүйцэтгэл 36.5 хувьтай байна.

Хүснэгт 13. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-т төвлөрүүлсэн
1	ЗДТГ	474,883.6	466,498.9	8,384.7	98.2	7,384.7
2	ИТХ	138,645.3	137,665.2	980.1	99.3	980.1
3	ЕБС	105,135.4	100,275.9	4,859.5	95.4	64.5
4	Цэцэрлэг	39,320.6	38,926.1	394.5	99.0	189.5
5	ЭМТ	32,552.8	37,549.1	(4,996.3)	115.3	3.7
6	Соёлын төв	31,390.7	31,169.0	221.7	99.3	221.7
7	ОНХС	522,874.9	190,893.0	331,981.9	36.5	
8	СХС	121,000.0	120,998.6	1.4	100.0	-
	<b>ДҮН</b>	<b>1,465,803.3</b>	<b>1,123,975.9</b>	<b>341,827.4</b>	<b>76.7</b>	<b>8,844.1</b>

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 76.7 хувь буюу 1,123,975.9 мянган байгаа нь ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг дутуу хэрэгжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бөмбөгөр сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 21,938.7 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300.0 мянга, нийт 23,238.7 мянган төгрөгийн санхүүжилт орсноос бараа үйлчилгээний бусад зардалд 16,164.1 мянган төгрөгийг зарцуулан, ЗДТГ хэмнэлтийн 7,074.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга асан М.Мөнх-Эрдэнэ 2022.01.01-2022.11.16-ны хооронд, аймгийн Засаг даргын 2022.12.14-ний өдрийн Б/41 дүгээр тушаалаар томилогдсон М.Баярсайхан, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Б.Нарангэрэл нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан ба, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг сумын төрийн сангийн мэргэжилтэн Б.Чулуундорж бэлтгэсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Их" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны баталсан төсөв 1,465,803.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,987.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 15,390.9 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.16-ны өдөр сумын Засаг даргаас 63 дугаар албан бичгээр ирүүлсэн ба Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаж, дараах үр дүн гарсан гэж тайлагнасан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ орон тоо дутуу ажилласан тул цалингийн зардал хэмнэгдсэн;
- Төсвийн хөрөнгөөр ямар нэгэн уралдаан тэмцээн зохион байгуулаагүй байна.

Хүснэгт 14. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	356,290.80	348,091.88	8,198.92
Хангамж, бараа материалын зардал	58,196.20	57,953.50	242.70
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,797.00	8,388.52	408.49
Урсгал шилжүүлэг	65,666.90	65,196.97	469.93

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бөмбөгөр сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 79 мэдээлэл оруулахаас 73 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Бөмбөгөр сумын ИТХ, ОНХС, СХС-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл дутуу байршуулсан, орхигдуулсан зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бөмбөгөр сумын харьяаны төсвийн шууд захирагчийн тайланд Төрийн аудитын байгууллагаас завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Бөмбөгөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн аудит хийж, 5 зөвлөмж өгсөн байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2022.06.22-ны өдрийн 703 дугаар албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн, аудитаар биелэлтийг тооцоход Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заасан бүрэлдэхүүн хэсгээр тайлбар гаргаж ирүүлээгүй, сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж, аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлэх зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

#### 4.7 Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан ба ЭМТ, сургууль, цэцэрлэг, Соёлын байгууллагын орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 232,055.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 18,880.0 мянган төгрөгийн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 29,700.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэн, 183,475.4 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Хүснэгт 15. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Материаллаг эсэх
A	1	2	3	4	5
1	Бөмбөгөр сумын ЗДТГ	Санхүүгийн тайланд 120,151.6 мянган төгрөгийн 16 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тэгээр, 100,350.0 мянган төгрөгийн 22 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах жилийг хасах нэг жилээр оруулсан байна.	220,501.6	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
2	Бөмбөгөр сумын ЗДТГ	Байгууллагын галч С.Мөнхбатад 2022 оны 7 дугаар сард 628,026 төгрөгийн цалин бодож, нийгмийн даатгалын шимтгэлд 72.230, хувь хүний орлогын албан татварт 37,586 төгрөг суутган тооцож, 513,036 төгрөгийг олгосныг байгууллагын дансанд буцаан төвлөрүүлсэн, татварт цалинг мэдээлж, татварыг шилжүүлсэн байна.	37.6	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
3	Бөмбөгөр сумын ЗДТГ	Сэлбэг хэрэгслийн 7-р сарын тайланд орлого харилцагч байгууллагаас ирүүлсэн баримттай материалын тоо ширхэг зөрсөн, орлого авахдаа харилцагч байгууллагаас ирүүлсэн зарлагын баримтыг үндэслээгүй, орлогыг бөөн дүнгээр furgоны мотор 4,000,000 төгрөгөөр орлого авсан байна.	4,000.0	Албан шаардлага өгсөн	Материаллаг бус
4	Бөмбөгөр сумын ЗДТГ	Мөнгөн хөрөнгийн журналыг анхан шатны баримттай тулган шалгахад 17,618.2 мянган төгрөгийн зардлыг төсвийн захирагчийн шийдвэргүйгээр олгосон, 31,955.7 мянган төгрөгийн гүйлгээний и-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	49,573.9	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
5	Бөмбөгөр сумын ЗДТГ	Бөмбөгөр сумын ЗДТГ-ын дарга, "Арцат дэл" хоршоотой 2022.04.15-ны өдөр ЗДТГ-ын "Хүүхэд хөгжлийн төв" байрны засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, сумын Засаг даргаар батлуулсан байна. Тус ажлыг малын худалдаа, мах, сүүн бүтээгдэхүүний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршоо 20,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээнд тусгасан бөгөөд дарга тушаал гаргаагүй байхад засварын үнэ төлбөрийг 2022.04.27-ны өдөр хоршоонд шилжүүлсэн, гэрээний хугацааг 2022.04.25-2022.06.01-ний өдөр хүртэл заасан байхад ажлыг хүлээн аваагүй, гэрээний үүргийг зөрчсөн байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.	20000	Албан шаардлага өгсөн	Материаллаг

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

6	Бөмбөгөр сумын ЗДТГ	Бөмбөгөр сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй 57,600.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг эрчим хүчний мотор аймгийн ОНӨГ-аас явуулсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор дутагдсан байхад арга хэмжээ авч ажиллаагүй байна.	57600	Албан шаардлага өгсөн	Материаллаг
7	Бөмбөгөр сумын ЗДТГ	Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга, "Юнител" ХХК-тай 2022.09.09-ний өдөр түрээсийн гэрээг 5 жилийн хугацаатай байгуулж, сард 150.0 мянган төгрөгийг төлүүлэхээр байхад түрээсийн төлбөрийг оруулаагүй байна.	1050	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг
8	Бөмбөгөр сумын ЗДТГ	Байгууллагын нярвын бэлтгэсэн тайланд 310.0 мянган төгрөгийн шаардах хуудас, зарлагын баримт байхгүй байна.	310	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг
<b>ДҮН</b>			<b>353,073.1</b>		
1	Бөмбөгөр сумын ИТХ	Тайлант онд 1,780.0 мянган төгрөгийн гүйлгээ и-баримтгүй олгосон байна.	1,780.00	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
2	Бөмбөгөр сумын ИТХ	Бэлэн бүтээгдэхүүний 2, 4, 5, 9, 10, бичиг хэргийн материалын тайлангийн 5, 9, 10, 11, 12 сарын тайлангуудад шаардах хуудас, зарлагын баримт байхгүй, нярвын тайлан, жолоочийн тооцооны хуудас хянаж баталгаажуулаагүй, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
3	Бөмбөгөр сумын ИТХ	Нярав 10 дугаар сарын шатахууны тайланг 200.0 мянга, бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэргийн материалын тайланг 3,5 дугаар сард 635.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.	835.80	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
4	Бөмбөгөр сумын ИТХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 21,431.4 мянган төгрөгийн орлогын 4, 6,313.2 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, хөрөнгө зарцуулах 20,740.3 мянган төгрөгийн 18 шийдвэрийг байршуулаагүй орхигдуулсан, 2022 онд 3 бүлгийн 20 нэр төрлийн 147 удаагийн мэдээлэл байршуулахаас 2 мэдээлэл хугацаа болоогүй, 108 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 8 мэдээлэл байршуулаагүй байна.	-	Албан шаардлага өгсөн	Материаллаг бус
<b>ДҮН</b>			<b>2,615.80</b>		
1	Бөмбөгөр сумын ОНХС	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдэд зардлыг шилжүүлэхдээ урьдчилж төлсөн зардал хоорондын тооцооны дансаар тусгалгүй шууд зардлаар тайлагнасан байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
2	Бөмбөгөр сумын ОНХС	"Хас ойл" ХХК-тай сумын Хөх толгойн 2-р багт эрчим хүчний өргөтгөлийг 2022.07.25-2022.08.15-ны хугацаанд хийж гүйцэтгэх 20,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, ажлыг 2022.12.28-ны өдрийн А/184 дүгээр захирамжаар хүлээн авсан бөгөөд ажлын санхүүжилтэд 2022.08.11-ний өдөр 14,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн, 6,000.0 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байхад	6,000.0	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

		санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.			
3	Бөмбөгөр сумын ОНХС	Сумын төвд ундны усан сан барих ажлын 18,000.0 мянган төгрөгийг "Цэлмэг өглөө" ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж, Хотын булангийн худаг засварлах 13,000.0 мянган төгрөгийн гэрээг "Баялаг алтан гандирс" ХХК-тай байгуулж шилжүүлсэн, Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх 12,000.0 мянган төгрөгийн гэрээг "Ган суурь мэццэ" ХХК-тай байгуулахдаа худалдан авах өвс, тэжээлийн тоо, үнийг тодорхой тусгаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
4	Бөмбөгөр сумын ОНХС	Сумын нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт ажилд 40,000.0 мянган төгрөг баталж, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулсан гэх боловч төрийн аудитын байгууллагад холбогдох баримт материалыг ирүүлээгүй, ОНХС-ийн судалгааг үнэн зөв гаргаж ирүүлээгүй, хогийн цэгийг түрж, булшлах ажил хүлээлцэх комиссын нэг гишүүний дүгнэлтийг бөглөөгүй анхан шатны баримтад хавсаргасан байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
5	Бөмбөгөр сумын ОНХС	Иргэн Эрдэнэбаттай нохой устгалын гэрээ байгуулж, 1,958.0 мянган төгрөгийг олгохдоо татварын и-баримтгүйгээр байхад хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.	195.8	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг
6	Бөмбөгөр сумын ОНХС	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст сумын Засаг даргын хөрөнгө зарцуулах 12,000.0 мянган төгрөгийн 2 шийдвэр, 94,958.0 мянган төгрөгийн 7 гэрээг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
<b>ДҮН</b>			<b>6,195.80</b>		
1	Бөмбөгөр сумын СХС	Санхүүгийн тайлангийн зээлийн авлага, хоршоо хөгжүүлэх сангийн программ дахь 2022.12.31-ний өдрөөрх зээлийн үлдэгдлийг тулган шалгахад 2022 онд зээл олгосон хоршоодын зээлийн хүүгийн 15,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	15,000.0	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
2	Бөмбөгөр сумын СХС	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 13 иргэний 12,971.8 мянган төгрөгийн зээлийг төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байхад гэрээний үүргээ зөрчсөн иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	12,971.8	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг
3	Бөмбөгөр сумын СХС	Тайлант онд сумын Засаг даргын захирамжаар 3 хоршоонд 100,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байхад таван сая төгрөгөөс дээших зарлагын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус
<b>ДҮН</b>			<b>27,971.82</b>		
<b>НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН</b>			<b>389,856.50</b>		

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 26,948.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн.

### 5.1. АЛБАН ШААРДЛАГА

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заасан бүрэлдэхүүн хэсгээр тайлбар гаргаж ирүүлээгүй, сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж, аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлэх, төсөвт байгууллага, сангуудад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгнө” гэснийг үндэслэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

2. Малын тоо толгойн албан татварыг анхны төсөвт батлаагүй, 2022 оны 6 дугаар сард хийсэн тодотголоор 74,469.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 47,520.7 мянган төгрөгийн татварыг оруулж, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул сумын малын тоо толгойн албан татварыг үнэн зөв төлөвлөж, 2022 оны дутуу татвар болон 2023 оны татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлага өгөв.

### 5.2. ЗӨВЛӨМЖ

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 389,856.5 мянган төгрөгийн 21 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг тооцож ажиллах

2. Илрүүлэлт: Өгсөн зөвлөмж:

3. **Илрүүлэлт:** Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" гэсний дагуу сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компанитай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээг сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Аж ахуйн нэгж байгууллагатай сум, орон нутгийн удирдлагуудтай байгуулсан гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байршуулж байх

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 389,856.5 мянган төгрөгийн 21 зөрчил илэрсэн байна.	1	-					1	-				
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заасан бүрэлдэхүүн хэсгээр тайлбар гаргаж ирүүлээгүй, сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж, аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлэх, төсөвт байгууллага, сангуудад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1				1	0						
<b>Дүн</b>	2	0	0	0	1	0	1	0	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Малын тоо толгойн албан татварыг анхны төсөвт батлаагүй, 2022 оны 6 дугаар сард хийсэн тодотголоор 74,469.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 47,520.7 мянган төгрөгийн татварыг оруулж, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна.	1	26,948.3			1	26,948.3		
Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана" гэсний дагуу сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компанитай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээг сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>26,948.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>26,948.3</b>	<b>1</b>	<b>0</b>

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 168/1/А050232/871А  
2023/7/НА.СТА - ТТЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөмбөгөр сум 2022 онд малын тоо толгойн албан татвараар 74,469,000 төгрөг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 47,520,700 төгрөгийн албан татварыг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 26,948,300 төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан, зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" зэргийг үндэслэн **ШААРДАХ нь:**

005040394  
D/2023-ASH

1. Сумын төсөвт төвлөрүүлэх малын тоо толгойн албан татварыг үнэн зөв тодорхойлон төлөвлөж, 2022 оны төлөгдөөгүй дутуу татвар, 2023 оны төлөвлөсөн татварыг хуулийн хугацаанд нь орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлэх
2. Аудитаар өгсөн 26,948,300 (Хорин зургаан сая есөн зуун дөчин найман мянга гурван зуун) төгрөгийн албан шаардлагын биелэлтийг, холбогдох нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>-т ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг дарга М.Баярсайхан, санхүүгийн албаны дарга Б.Нарангэрэл, татварын байцаагч Ц.Мөнхжаргал нарт хариуцуулав<sup>2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН<sup>3</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор хот, 1 дүгээр баг, Нутгийн удирдлагын ордон. Утас: 7044-2584

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдээдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 169/2/А0580238/877А  
2023/7/НА - СТА - ТТЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөмбөгөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заасан бүрэлдэхүүн хэсгээр тайлбар гаргаж ирүүлээгүй, сумын санхүүгийн албаны дарга татварын байцаагчтай тооцоо нийлж, аймгийн Татварын хэлтэст татварын мэдээг үнэн зөв мэдээлэх, төсөвт байгууллага, сангуудад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд дээрх зөрчлүүд давтагдан гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4 дэх "54.5.Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх орлого;", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох,

005040398

D/2023-ASH

давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгнө” зэргийг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөрчлийг арилгах
2. Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг, холбогдох нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>-т ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг дарга М.Баярсайхан, санхүүгийн албаны дарга Б.Нарангэрэл, татварын байцаагч Ц.Мөнхжаргал нарт хариуцуулав<sup>2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН<sup>3</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Б.ДОЛЖМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор хот, 1 дүгээр баг, Нутгийн удирдлагын ордон. Утас: 7044-2584

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

<sup>3</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”